



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/387

Мөрөн сум

Багц болгон задлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 6.0.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, 45 дугаар зүйлийн 45.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай” А/641 дугаартай тушаалын 4 дүгээр хавсралтын VI.1.17 батлагдсан “Цаг уурын өртөөний барилга Хөвсгөл аймгийн Шинэ-идэр, Тариалан, Цагаан-Үүр сум” төсөл арга хэмжээг хавсралтаар багц болгон баталсугай.

2. Дээрх арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан дээрх арга хэмжээний 640,000,000 (зургаан зуун дөчин сая) төгрөгийг холбогдох хууль журамд нийцүүлэн гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх, төлөвлөгдсөн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, тайлагнаж ажиллахыг аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.



ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712011152

Захирамж2024



Аймгийн Засаг даргын 2024 оны  
07 дугаар сарын 23 өдрийн  
А/387 дугаар захирамжийн хавсралт

БАГЦ БОЛГОН ЗАДЛАСАН ЖАГСААЛТ

№	Зардлын утга	Нийт үнэ
1	Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл аймгийн Шинэ-идэр сум/	200,000,000
2	Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл аймгийн Тариалан сум/	200,000,000
3	Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сум/	240,000,000
	НИЙТ	640,000,000

-----oOo-----